

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс нь жилд 700 гаруй лифт, лифтний тоног төхөөрөмжийг БНХАУ, БНСУ, БНТУ, ОХУ -аас импортлон угсарч, ашиглаж байна.

Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдаж хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Засгийн газрын 106 дугаар тогтоолын дагуу шинээр “Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” баримт бичгийн төслийг тус яамнаас боловсрууллаа.

“Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” баримт бичиг нь стандартуудыг нэвтрүүлэн хэрэглэх, бөгөөд дагаж мөрдөх стандартуудыг Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн С/32 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд:

1. Нэр томъёо тодорхойлолт MNS GOST 33605:2025
2. Лифт, хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн хэрэгцээг тусгасан хүртээмжтэй байдлын тусгай шаардлага MNS GOST 33652:2025
3. Лифт Аюулгүй байдлын шаардлага, зориуд эвдэхээс хамгаалах MNS GOST 33653:2025
4. Лифт Гэрчилгээжүүлэх явцад оношлогоо (туршилт) хэмжилт хийх дүрэм ба аргачлал, Сорилтын дээжийг сонгож авах дүрэм MNS GOST 33984:2:2025
5. Лифтний ослоос хамгаалах хэрэгслийг гэрчилгээжүүлэх үед оношлогоо туршилт, хэмжилт хийх дүрэм ба аргачлал. Сорилтын дээжийг сонгож авах дүрэм MNS GOST 33984:3:2025
6. Лифт Галын аюулгүй байдал - MNS GOST 34442:2025
7. Лифт. Лифтийг барилга байгууламжид суурилуулахад тавигдах аюулгүй байдлын тусгай шаардлага - MNS GOST 34581:2025
8. Хүн зөөврийн лифт. Гал сөнөөгчдийн лифт MNS GOST R 34305:2025
9. Лифт, эскалатор ба зорчигчдын урсдаг зам. Эрсдэлд дүн шинжилгээ хийх ба бууруулах арга зүй MNS GOST R 53387:2025
10. Лифт, лифтийг ашиглалтад оруулах үед тохирлыг үнэлэх дүрэм ба аргачлал MNS GOST R 53782:2025
11. Лифт, лифтийг ашиглах явцад тохирлыг үнэлэх дүрэм ба аргачлал MNS GOST R 53783:2025
12. Лифт. Угсралт болон суурилуулалтын аюулгүй байдалд тавигдах ерөнхий шаардлага. Ачаа зөөвөрлөх лифт MNS GOST R 56943:2025

Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт баримт бичиг нь 9 бүлэгтэй, 3 хавсралт, дээрх 12 стандартуудаас бүрдэнэ.

Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт баримт бичиг батлагдснаар иргэдийн амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд аюул учруулж болзошгүй лифт түүний ослоос хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор оруулах, ашиглахыг хязгаарлах, хориглох бүхий л арга хэмжээг авч шийдвэр гаргах үүрэгтэй байхаар зохицуулж өгсөн.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ЛИФТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН  
ЗОХИЦУУЛАЛТ БАТЛАХ ТУХАЙ

2026 оны ... дүгээр  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1. дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

1. “Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгаланд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолыг 2026 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Засгийн газрын 2026 оны ... дугаар  
сарын ....-ны өдрийн ... дугаар  
тогтоолын хавсралт

## **ЛИФТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

2026 он

# **ЛИФТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

## **Өмнөх үг**

“Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг (цаашид “техникийн зохицуулалт” гэх) Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 22-ны 12/2022 дугаар тушаалаар батлагдсан техникийн даалгаврын дагуу Монгол улсын нутаг дэвсгэр дээр лифтний аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагыг бүх нийтээр биелүүлэх, зорилгоор боловсруулсан болно.

## **Бүлэг 1. Хамрах хүрээ**

1. Энэхүү “Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” нь Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа бүх лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэлд (зөөлөвч тулгуур, баригч, хурд хязгаарлагч, хонгилын хаалганы түгжээ, ослоос хамгаалах гидравлик хэрэгсэл) хамаарна.

“Техникийн зохицуулалт” нь дараах зориулалтаар ашиглагдаж байгаа лифтэнд хамаарахгүй:

- уул уурхай, нүүрс үйлдвэрлэлийн уурхайд;
- усан онгоц болон бусад хөвөгч төхөөрөмжид;
- хайгуулын болон далайн өрөмдлөгийн тавцанд;
- онгоц болон нисэх төхөөрөмжид;

мөн дараах хийцтэй лифтэнд:

- хэдрэг араат эсвэл шурган өргөх механизмтай;
- цэргийн тусгай зориулалттай.

2. “Техникийн зохицуулалт” нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, түүнчлэн лифтний зориулалт, аюулгүй ашиглах талаар худалдан авагчийг (хэрэглэгч) алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэлд тавих шаардлагыг тогтоодог.

## **Бүлэг 2. Нэр томьёо ба тодорхойлолт**

“Техникийн зохицуулалт”-д дараах нэр томьёо ба тодорхойлолтуудыг ашиглана:

1) зөөлөвч тулгуур – бүхээг, эсрэг ачаа, ажлын хязгаарын байрлалаас хэтэрснээс зорчигч гэмтэх эсвэл тоног төхөөрөмж эвдрэх эрсдэлийг бууруулахын тулд бүхээг, эсрэг ачааны хурдыг сааруулах, хөдөлгөөнийг хязгаарлах зориулалттай тоноглол;

2) ослоос хамгаалах гидроаппарат - бүхээгийг унахаас сэргийлэх зориулалттай,

гидроцилиндртэй холбогдсон, шингэний тоноглол (тохируулах хавхалга);

3) хонгилын хаалганы цоож - хонгилын хаалгыг түгжих зориулалттай, автомат тоноглол;

4) үйлчилгээний талбай - лифтний тоног төхөөрөмжийн зэргэлдээ байрладаг, үйлчилгээний ажилтнууд түүнд үйлчлэх зориулалттай талбай;

5) үйлдвэрлэгч - техникийн зохицуулалтын шаардлагын дагуу лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэх эсвэл нийлүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг дотоод, гадаадын иргэн эсвэл хуулийн этгээд;

6) бүхээг - хүн ба (эсвэл) ачааг барилгын нэг түвшнээс нөгөөд шилжүүлэх зориулалттай, лифтний эд анги;

7) лифт - бүхээгт хүн ба (эсвэл) ачааг байрлуулан, босоо тэнхлэгтэй 15°-аас ихгүй налуу өнцөг үүсгэн, барилгын нэг түвшнээс нөгөөд хөшүүн чиглүүлэгчийн дагуу шилжүүлэх зориулалт бүхий тоног төхөөрөмж;

8) баригч – үйлдвэрлэгчийн тогтоосон хурд хэтрэх эсвэл татах элемент тасрах үед бүхээгийг (эсрэг ачаа) чиглүүлэгч дээр барьж зогсоох зориулалт бүхий тоноглол;

9) лифтний шинэчлэлт - ашиглагдаж байгаа лифтний аюулгүй байдал, техникийн түвшнийг техникийн зохицуулалтын дагуу сайжруулах арга хэмжээ;

10) хэвийн хурд – үйлдвэрлэгчээс тогтоосон, лифтний бүхээг шилжих хурд;

11) хурд хязгаарлагч – бүхээг, эсрэг ачааны шилжих хурд тогтоосон хэмжээнээс хэтрэх үед баригчийн механизмыг идэвхжүүлэх зориулалттай тоноглол;

12) лифтний паспорт - үйлдвэрлэгчийн тухай мэдээлэл, лифтийг үйлдвэрлэсэн огноо, үйлдвэрийн нэр дугаар, лифтний тоноглолуудын техникийн үндсэн тодорхойлолт, ослоос хамгаалах хэрэгслийн өгөгдөл, лифтийг ашиглах хугацаа түүнчлэн ашиглалтын явцад хаяглалт, тэмдэглэгээ хийх зориулалт бүхий баримт бичиг;

13) ашиглалтын зориулалт - үйлдвэрлэгчээс ашиглалтын баримт бичгийн дагуу лифтийг ашиглах зориулалтыг тодорхойлсон мэдээлэл;

15) ажлын тавцан - лифтний тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээний ажлыг гүйцэтгэх ажилтнуудыг байрлуулах зориулалттай талбай;

16) загварын дээж - лифтний үндсэн төрөл, хэмжээ, шинж чанар, бүлэг лифт;

17) төрөл хэмжээний хүрээ - хийц загварын нэгдсэн шийдлээр тодорхойлогддог, даац, хурд, өргөх өндөр эсвэл лифтний өргүүр, бүхээг, удирдлагын систем зэрэг тоноглолуудын иж бүрдэл түүнчлэн тоног төхөөрөмжийн байршлаар ялгаатай лифтнүүд;

18) лифтний техникийн үйлчилгээ - лифтийг ашиглах явцад түүний найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилготой багц үйлдэл;

19) лифтний ослоос хамгаалах хэрэгсэл - лифтний аюулгүй ажиллагааг хангах зориулалттай техникийн хэрэгсэл;

20) диспетчерийн хяналтын төхөөрөмж - лифтний ажиллагааг алсаас хянах түүнчлэн диспетчертэй (оператор) холбогдох техникийн хэрэгсэл;

21) лифтний ашиглалт - лифтийг ашиглах хугацаанд техникийн үйлчилгээ, засварын ажлыг хийх аргаар түүний техникийн чадварыг сэргээн, зориулалтын дагуу ашиглах, хэвийн ашиглалтыг хангах үйл ажиллагаа;

### **Бүлэг 3. Нийлүүлэлтийн шаардлага**

1. Лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг зах зээлд нийлүүлэх үйл ажиллагаанд энэхүү “техникийн зохицуулалт”-ыг дагаж мөрдөнө.

2. Үйлдвэрлэгдэж нийлүүлсэн лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэл нь үйлдвэрлэгчийн дагалдах баримт бичгийн шаардлага, техникийн зохицуулалтын 4-р бүлгийн 2-р заалтад нийцүүлэн зориулалтын дагуу ашиглагдсан тохиолдолд, үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалтын хугацааны туршид аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангах ёстой.

3. Үйлдвэрлэгдэж, нийлүүлсэн лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн дагалдах баримт бичгийг монгол хэл болон (эсвэл) орос, англи хэл дээр бүрдүүлсэн байх ёстой.

Дагалдах баримт бичиг дараах хэсгээс бүрдэнэ:

- ашиглалтын гарын авлага (заавар);
- техникийн паспорт;
- угсралтын зураг;
- элементүүдийн жагсаалт бүхий цахилгааны зарчмын схем;
- гидравлик схем (шингэний хөтлүүртэй лифтийн хувьд);
- лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн гэрчилгээний хуулбар (6-р бүлэг, 2.7 заалтыг харгалзана), галыг эсэргүүцэх хаалга (хэрэв байгаа бол).

Ашиглалтын гарын авлагад (заавар) дараах мэдээллийг оруулна:

- угсралт, тохируулга, зүгшрүүлэлт, туршилт, шалгах журмыг тусгасан суурилуулалтын заавар;
- лифтийг ашиглах хугацаанд түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тусгасан ашиглалтад оруулах, ашиглах зориулалт, техникийн үйлчилгээ, магадлал, үзлэг, засвар, туршилт хийх арга бүхий ашиглалтын заавар;
- түргэн элэгддэг эд ангиудын жагсаалт;
- зорчигчийг бүхээгээс аюулгүй гаргах аргачлал;
- лифтийг устгалд оруулахын өмнө ашиглалтаас гаргах заавар.

4. Лифтийг ашиглах хугацаанд түүний товч мэдээллийг тодорхой, ойлгомжтой байдлаар дүрсэлж байрлуулах ёстой. Үүнд: үйлдвэрлэгчийн нэр ба (эсвэл) барааны тэмдэг; лифтийг таних (үйлдвэрийн) дугаар; үйлдвэрлэсэн он.

Мэдээллийг бүхээгт эсвэл түүний дээр үйлчилгээний ажилтнууд харах боломжтой газарт байрлуулна.

5. Лифтний ослоос хамгаалах хэрэгсэл дээр үйлдвэрлэгчийн нэр, барааны тэмдэг, төхөөрөмжийг таних дугаар бүхий мэдээллийг лифтийг ашиглах нийт хугацааны туршид тодорхой, ойлгомжтой дүрслэлээр байрлуулах ёстой;

#### **Бүлэг 4. Аюулгүй байдлын шаардлага**

1. Лифтийг төлөвлөх, үйлдвэрлэх, суурилуулах болон ашиглахаар тогтоосон хугацааны туршид түүний аюулгүй байдлыг хангахын тулд лифтний зориулалт, ашиглалтын нөхцөлийг харгалзан аюулгүй байдлын ерөнхий шаардлагыг хангах арга хэмжээг 1-р хавсралтад заасан тусгай шаардлагын дагуу авна.

Эрчим хүчний хэмнэлтийн ангиллыг лифтний пайз болон техникийн баримт бичигт заасан байна.

2. Барилга байгууламжид суурилуулсан лифтний аюулгүй байдлыг хангахын тулд ашиглалтад оруулахаас өмнө дараах шаардлагыг хангасан байна:

2.1. Лифт угсралтын ажлыг угсралт, тохируулга хийх зааврыг тусгасан, суурилуулалтын баримт бичиг болон лифтийг угсрах төслийн дагуу мэргэшсэн ажилтнууд гүйцэтгэнэ;

2.2. Тохирлын баталгаажилт ба лифтийг суурилуулсны дараа ашиглалтад оруулахдаа энэхүү техникийн зохицуулалтын 6-р бүлэгт заасан зааврыг дагаж мөрдөнө.

3. Ашиглалтын тогтоосон хугацаанд лифтний аюулгүй байдлыг хангуулахын тулд дараах шаардлагыг биелүүлнэ:

3.1. Лифтийг зориулалтын дагуу ашиглаж, техникийн үйлчилгээ, засвар, үзлэгийг үйлдвэрлэгчээс ирүүлсэн ашиглалтын зааврын дагуу гүйцэтгэх;

3.2. Лифтний техникийн үйлчилгээ, засварын ажлыг мэргэшсэн ажилтнаар хийлгэх;

3.3. Лифтний техникийн магадлалын актаар тохирлын үнэлгээг—энэхүү техникийн зохицуулалтын 6-р бүлэгт заасны дагуу хийх;

3.4. Ашиглалтын хугацаа нь дууссаны дараа лифтийг шинэчлэх, солих боломж нөхцөлийг тодорхойлох, түүний ашиглах хугацааг зориулалтын дагуу сунгах зорилготой тохирлын үнэлгээг хийлгүйгээр ашиглахыг хориглоно.

Техникийн зохицуулалтын 6-р бүлэгт заасны дагуу тохирлын үнэлгээг хийнэ.

4. Энэхүү техникийн зохицуулалт хүчин төгөлдөр болохоос өмнө ашиглалтад орсон лифтний паспорт дээр ашиглалтын хугацааны талаар мэдээллийг бичээгүй бол лифтний ашиглалтын хугацааг ашиглалтад оруулсан өдрөөс хойш 25 жилээр

ТОГТООНО.

5. Хуучин лифтийг устгалд оруулах ажлын аюулгүй байдлын шаардлагыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжоор тогтооно.

#### **Бүлэг 5. Аюулгүй байдлын шаардлагын тохирлыг хангах**

“Техникийн зохицуулалт”-д лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг нийцүүлэх нь түүний аюулгүй байдлын шаардлагыг шууд дагаж мөрдөх эсвэл тус “техникийн зохицуулалт”-тай холбоотой боловсруулсан стандартуудын шаардлагыг дагаж мөрдсөнөөр биелэгдэнэ.

Энэхүү техникийн зохицуулалттай харилцан уялдаатай гарсан стандартуудын шаардлагыг сайн дурын үндсэн дээр дагаж мөрдсөнөөр лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслүүд нь тус зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг илэрхийлнэ.

#### **Бүлэг 6. Лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн тохирлыг баталгаажуулах**

1. 2-р хавсралтад заасан лифт түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийн тохирлыг баталгаажуулахдаа, энэхүү техникийн зохицуулалтын шаардлагад нийцүүлж ашиглалтад оруулахаас өмнө гэрчилгээжүүлнэ.

2. Лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийг гэрчилгээжүүлэх ажлыг дараах журмаар гүйцэтгэнэ:

2.1. Тогтоосон журмаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага (цаашид баталгаажуулалтын байгууллага гэх) нь хүсэлт гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр 2-р хавсралтад заасан лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийг гэрчилгээжүүлнэ;

2.2. Олноор ~~нь тасралтгүй~~ үйлдвэрлэгдэх лифт ба түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийг гэрчилгээжүүлэх ажлыг 3-р хавсралтад заасан 1с схемийн дагуу гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд хүсэлт гаргагчийг лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн үйлдвэрлэгчээр (үйлдвэрлэгчийг төлөөлөгч) тооцно;

2.3. Нэг удаа үйлдвэрлэгдэх лифт ба түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийг гэрчилгээжүүлэх ажлыг 3-р хавсралтад заасан, 4с (нэг удаагийн үйлдвэрлэлийн хувьд) ба хэсэг хугацаанд үйлдвэрлэгдэх лифт ба түүний ослоос хамгаалах хэрэгслүүдийн багцыг 3с (хэсэг хугацаанд үйлдвэрлэгдэх багц) схемийн дагуу гүйцэтгэнэ;

2.4. Гэрчилгээ авах хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг өргөдөлд тусгана:

- өргөдөл гаргагчийн нэр, хаяг;
- үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- гэрчилгээжүүлэх объектын тодорхойлолт, мэдээлэл;

- гэрчилгээжүүлэх об'ектод туршилт хийх байгууллагын мэдээлэл;

- энэхүү техникийн зохицуулалтын шаардлагад лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг нийцүүлэхийн тулд сайн дурын үндсэн дээр мөрдөж буй стандартын талаарх мэдээлэл;

2.5. Энэхүү техникийн зохицуулалтын шаардлагатай нийцэж байгааг гэрчилсэн дараах баримт бичгийг гэрчилгээжүүлэх өргөдөлд хавсаргана:

а) лифтийг гэрчилгээжүүлэхэд:

- техникийн тодорхойлолт;

- ашиглалтын гарын авлага (заавар);

- элементүүдийн жагсаалт бүхий цахилгааны зарчмын схем;

- шингэний хөтлүүртэй лифтний эд ангиудын жагсаалт бүхий схем зураг;

- үйлдвэрлэгч эсвэл түүний төлөөлөгчийн (хэрэв байгаа бол) гүйцэтгэсэн туршилт ба хэмжилтийн тайлан, эрсдэлийн шинжилгээ;

- техникийн зохицуулалттай нийцүүлсэн ослоос хамгаалах хэрэгслийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай тохиолдолд түүний дагуу боловсруулсан туршилт, хэмжилтийн тайлан;

- итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээний хуулбар (хэрэв байгаа бол);

б) лифтний ослоос хамгаалах хэрэгслийг гэрчилгээжүүлэхэд:

- техникийн баримт бичиг (тайлбар, бүдүүвч зураг);

- итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээний хуулбар (хэрэв байгаа бол);

2.6. Лифтийг гэрчилгээжүүлэх хүсэлт гаргагч нь богино хугацаанд үйлдвэрлэгдэх лифт эсвэл тасралтгүй олноор нь үйлдвэрлэгдэх лифтний загварын дээжийг туршилтад оруулах зорилгоор нэг удаа үйлдвэрлэж, угсрах ба энэхүү бүлгийн а) хэсгийн 2.5 дахь заалтад заасан баримт бичгийг ирүүлнэ;

Лифтийг гэрчилгээжүүлэхээр хүсэлт гаргагч нь нэг удаа эсвэл богино хугацаанд түүнчлэн олноор нь үйлдвэрлэж, байгууламжид угсарсан лифтний сорилтын дээжийг туршилтад оруулах зорилгоор энэхүү бүлгийн 2.5 заалтын а) хэсэгт заасан баримт бичгийг ирүүлнэ;

2.7. Хүсэлт гаргагч нь 2-р хавсралтад заасан лифтний ослоос хамгаалах хэрэгслийг гэрчилгээжүүлэхдээ туршилт хийж, баталгаажуулах байгууллагад дараах баримт, материалыг ирүүлнэ:

- нэг удаа үйлдвэрлэх тохиолдолд ослоос хамгаалах хэрэгслийг нь, хэсэг хугацаанд үйлдвэрлэгдэх багц эсвэл тасралтгүй олноор нь үйлдвэрлэх ослоос хамгаалах хэрэгслийн загварын дээжийг;

- ослоос хамгаалах хэрэгслийг гэрчилгээжүүлж, туршилтад оруулахад шаардлагатай бүрэлдэхүүн хэсгүүд;

- энэ бүлгийн 2.5 заалтын б) хэсэгт заасан баримт бичгүүд.

Лифт үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн, өөрийн үйлдвэрлэсэн лифтийг иж бүрдүүлэхэд ашигладаг эсвэл өөрийн үйлдвэрлэсэн лифттэй ижил төрлийн лифтний ослоос хамгаалах хэрэгслийг сэлбэг болгон нийлүүлдэг тохиолдолд лифтний ослоос хамгаалах хэрэгсэл нь гэрчилгээжүүлэхэд заавал хамрагдахгүй. Энэхүү лифтнүүдийн ослоос хамгаалах хэрэгслийг туршилтад оруулах журмыг “техникийн зохицуулалт”-ын сайн дураар хэрэгжүүлэх стандартын жагсаалтад тусгана.

Туршилтын үр дүнг тэмдэглэлээр баримтжуулна. Тэмдэглэлийн хуулбарыг лифтийг гэрчилгээжүүлэх үед ирүүлнэ;

2.8. Баталгаажуулалтын байгууллага нь энэхүү техникийн зохицуулалтын 1-р хавсралтад заасан лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг туршигдаа тэдгээрийн үндсэн ба ижил төстэй шинж чанаруудыг тодорхойлох аргыг ашиглана;

2.9. Лифтний үндсэн тодорхойлолтод:

- бүхээг байгаа эсэх;

- хөшүүн чиглүүлэгч байгаа эсэх;

- чиглүүлэгчийн босоо чиглэл дэх налуу өнцөг нь 15 градусаас ихгүй байх;

- бүхээгийг өргөж, буулгах хөтлүүр байгаа эсэх;

2.10. Техникийн зохицуулалтын 2-р бүлэгт заасан мэдээллийн тодорхойлолтуудыг үндэслэн, лифтний ослоос хамгаалах хэрэгслийн үндсэн үзүүлэлт, үйл ажиллагааны зориулалтыг 2-р хавсралтад оруулсан болно.

Хүсэлт гаргагчаас ирүүлсэн техникийн баримт бичгийг ашиглаж лифтийг тодорхойлох ажлыг гүйцэтгэнэ.

Бүтээгдэхүүнийг объектод ирүүлэх эсвэл ирүүлэхгүй байх нь техникийн зохицуулалтын дагуу туршиж тодорхойлох ажлын үр дүнд нөлөөлнө;

2.11. Зохих ёсоор итгэмжлэгдсэн туршилтын лаборатори (төв) лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийг гэрчилгээжүүлэхдээ судалгаа (туршилт) ба хэмжилтийн ажлыг гүйцэтгэнэ;

2.12. Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт гаргагчтай байгуулсан гэрээнд

заасан хугацаанд, баталгаажуулалтын ажлыг батлагдсан журмын дагуу хийж, тохирлын гэрчилгээг олгох, эсвэл олгохоос татгалзсан шийдвэрийг гаргана.

Тохирлын гэрчилгээ ба түүний хавсралтад лифтний төрөл (загвар), үйлдвэрлэгч байгууллага, улс, түүнчлэн лифтний эд анги, ослоос хамгаалах хэрэгслийн тухай дараах мэдээллийг агуулсан байна:

- эргүүлэг;
- шингэний төхөөрөмж (шингэний хөтлүүртэй лифтний хувьд);
- удирдлагын систем (контроллер);
- бүхээгийн хаалганы хөтлүүр;
- хонгилын хаалга;
- хонгилын хаалганы цоож;
- баригч;
- хурд хязгаарлагч;
- зөөлөвч тулгуур;
- ослоос хамгаалах шингэний аппарат.

Тохирлын гэрчилгээг олгохоос татгалзах тухай шийдвэрт лифт эсвэл түүний ослоос хамгаалах хэрэгсэл нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэхгүй байгаа тухай үндэслэлийг бодитоор агуулсан байх ёстой.

Хүсэлт гаргагч нь үл тохирлын шаардлагыг биелүүлсний дараа тохирлын гэрчилгээ авах өргөдлийг баталгаажуулалтын байгууллагад дахин гаргана;

2.13. Олноор нь тасралтгүй үйлдвэрлэгдэх лифт ба түүний ослоос хамгаалах хэрэгслийн тохирлын гэрчилгээ хүчинтэй байх хугацаа нь энэхүү техникийн зохицуулалтын 2-р хавсралтад заасан 1с схемийн дагуу таван жилээс хэтрэхгүй байх ёстой.

Олноор тасралтгүй нь үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд үйлдвэрлэгчээс ашиглалтад оруулсан лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн хувьд тохирлын гэрчилгээ нь лифтний ашиглалтын нийт хугацаанд хүчинтэй байна.

Нэг удаа эсвэл богино хугацаанд үйлдвэрлэгдэх багц лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн хувьд энэхүү техникийн зохицуулалтын 3-р хавсралтын 3с, 4с схемийн дагуу олгосон тохирлын гэрчилгээ нь лифтийг ашиглах хугацаа дуусах хүртэл хүчинтэй байна;

2.14. Олноор нь тасралтгүй үйлдвэрлэгдэх лифт, түүний ослоос хамгаалах

хэрэгслийн тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссаны дараа хүсэлт гаргагч нь энэхүү бүлэгт заасан журмын дагуу тохирлын гэрчилгээг авахаар баталгаажуулалтын байгууллагад өргөдөл гаргана. Эсвэл гэрчилгээг анх олгосон баталгаажуулалтын байгууллагад тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах өргөдлийг хүргүүлнэ. Энэхүү техникийн зохицуулалтын 3-р хавсралтын 1с схемийн дагуу тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацааг гэрчилгээжүүлэх ажлыг өмнө нь хийсэн баталгаажуулалтын байгууллагын шийдвэрээр, хүсэлт гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, гэрчилгээжүүлэх объектын хяналт шалгалтын үр дүнг (1с схемийн дагуу гэрчилгээжүүлэхэд) үндэслэн 5 жил хүртэл сунгаж болно.

Тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацааг сунгуулахын тулд хүсэлт гаргагч нь хүсэлтээ баталгаажуулалтын байгууллагад илгээх бөгөөд түүнд гэрчилгээжсэн лифт болон ослоос хамгаалах хэрэгслийн загварт сүүлийн шалгалт хийснээс хойш өөрчлөлт ороогүй тухай мэдээллийг агуулсан байна.

Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хяналт шалгалтын үр дүнг үндэслэн тохирлын гэрчилгээний хугацааг сунгах эсвэл сунгахаас татгалзах шийдвэрийг 10 хоногийн дотор гаргаж, хариу мэдэгдэнэ. Гэрчилгээний хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах тухай шийдвэрт лифт болон ослоос хамгаалах хэрэгсэл нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэхгүй байгаа тухай бодит шалтгаан, үндэслэлийг агуулсан байх ёстой.

Баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээний хугацааг сунгасан эсвэл сунгахаас татгалзсан тухай мэдээллийг тохирлын гэрчилгээний шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих эрх бүхий төрийн төв байгууллагад (хяналтын) шийдвэр гаргасан өдрөөс хойш 10 хоногийн дотор, энэхүү техникийн зохицуулалтын \*6.2.14.4-ийг үндэслэн илгээнэ;

2.15. Хүсэлт гаргагч нь 2-р хавсралтад дурдсан лифтний ослоос хамгаалах хэрэгсэл түүнчлэн лифтний загварт оруулсан өөрчлөлт нь түүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх талаар тохирлын гэрчилгээ олгосон баталгаажуулалтын байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийж, өөрчлөлт оруулсан лифтний загвар ба түүний ослоос хамгаалах хэрэгсэлд тохирлын гэрчилгээг дахин олгох, эсвэл тэдгээрт туршилтыг шинээр дахин хийх шаардлагатай гэсэн шийдвэрийг гаргана;

2.16. Энэхүү бүлгийн 2.15 заалтад заасан шаардлагыг хангаагүй эсвэл гэрчилгээжсэн бүтээгдэхүүнд хийсэн хяналт, шалгалтын үр дүн нь хангалтгүй тохиолдолд баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээний (1с схемийн дагуу) хүчинтэй байх хугацааг түдгэлзүүлнэ;

2.17 Бүтээгдэхүүнийг борлуулахдаа дараах баримт бичгийн багцыг хадгална:

- лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэлд - үйлдвэрлэгч лифтний үйлдвэрлэлийг татан буулгасан (зогсоосон) өдрөөс хойш 10-аас доошгүй жилийн

хугацаанд;

- багц лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэлд (нэгж бүтээгдэхүүн) - багцаас (нэг бүтээгдэхүүн) сүүлчийн бүтээгдэхүүнийг худалдагч (нийлүүлэгч) борлуулсан өдрөөс хойш 10-аас доошгүй жилийн хугацаанд.

Техникийн зохицуулалтын шаардлагад лифт нь нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахад ашигласан баримт бичиг, тохирлын гэрчилгээний хуулбаруудыг тохирлын гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд болон хугацаа дууссаны дараа таван жилд, тохирлын гэрчилгээ олгосон баталгаажуулалтын байгууллагад хадгална;

2.18. Гэрчилгээжүүлэхээр ирүүлсэн багц баримт бичгүүдийг монгол, (эсвэл) орос, англи хэл дээр боловсруулна.

3. Байгууламжид суурилуулсан лифтийг ашиглалтад оруулахаас өмнө техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх ажлыг лифтний тохирлыг мэдүүлэх хэлбэрээр тус зохицуулалтын 3-р хавсралтад заасан 4д схемийн дагуу дараах дарааллаар гүйцэтгэнэ:

3.1. Лифтний тохирлын мэдүүлгийг өөрийн нотлох баримт болон итгэмжлэгдсэн туршилтын лабораторийн (төв) оролцоотой боловсруулсан нотлох баримтын үндсэн дээр гүйцэтгэнэ.

Лифтийг суурилуулсны дараа түүний ажиллагааг шалгасан тэмдэглэл, техникийн паспорт, суурилуулалтын зураг, төслийн баримт бичгийг өөрийн нотлох баримтад ашиглана.

Лифтний суурилуулалт нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахад шаардлагатай мэдээлэл, хэмжээсийг суурилуулах зурагт оруулсан байх ёстой. Зурагт хонгил, машин, блокийн өрөөний нүүрний болон хажуугийн (хэмжээтэй) зургийг тусгах бөгөөд лифтний эд ангиудын байршил, харилцан холболт түүнчлэн барилгын хэсэгт (бүтэц) лифтнээс үзүүлэх ачааллын талаарх ойлголтыг өгнө;

3.2. Өргөдлийг итгэмжлэгдсэн туршилтын лабораторид (төв) ирүүлнэ;

3.3. Итгэмжлэгдсэн туршилтын лаборатори (төв) нь өргөдөл гаргагчтай байгуулсан гэрээнд заасан хугацааны дагуу үзлэг шалгалт, судалгаа, туршилт, хэмжилтийг хийнэ. Энэ тохиолдолд дараах зүйлийг гүйцэтгэнэ:

- барилга байгууламжид лифтийг суурилуулах төсөл нь лифтний тоног төхөөрөмжийг угсрах баримт бичгүүдтэй нийцэж байгаа эсэхийг шалгах;

- лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн ажиллагааг шалгах;

- цахилгаан тоног төхөөрөмж, сүлжээний тусгаарлагчуудыг турших, лифтний тоног төхөөрөмжийн газардуулгад (нойлтуулга) нүдэн үзлэг болон хэмжих

шалгалтыг хийх;

- цахилгаан хөтлүүртэй лифтний тоормосны систем болон ган татлагыг хөтлөх шкив (үрэлтийн хүрд) ба татах элементүүдийн барьцалдааг турших;

- шингэний хөтлүүртэй лифтний гидроцилиндр ба дамжуулах хоолойн битүүмжлэлийг турших;

- бүхээгийн бат бэх байдал, татах элементүүд, бүхээгийн тулгуур ба (эсвэл) зүүлтүүр тэдгээрийн бэхэлгээний элементүүдийг турших;

3.4. Үзлэг шалгалт, судалгаа, туршилт, хэмжилтийн үр дүнг тэмдэглэлээр баримтжуулж, хуулбарыг лифтний паспортад хавсаргана.

Итгэмжлэгдсэн туршилтын лабораторийн (төв) мэргэжилтэн лифтний паспорт дээр үзлэг шалгалт, судалгаа, туршилт, хэмжилтийн үр дүнгийн тухай бичилтийг хийнэ;

3.5. Лифт нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа тухай мэдээллийг түүний паспортад хавсаргана. Лифтний паспорт, мэдээллийг түүний ашиглалтын хугацааны туршид ашиглагч хадгалах ёстой;

3.6. Лифтийг ашиглалтад оруулахаас өмнө түүнийг угсралт, тохиргоо, туршилт хийхээс бусад тохиолдолд хүн ба (эсвэл) ачаа тээвэрлэхийг хориглоно;

3.7. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон дүрэм, журмын дагуу лифтийг ашиглалтад оруулна.

4. Ашиглалтын тогтоосон хугацаанд лифтний тохирлын үнэлгээг 12 сарын хугацаанд нэгээс доошгүй удаа хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу итгэмжлэгдсэн (эрх бүхий) байгууллага техникийн магадлалын хэлбэрээр гүйцэтгэнэ.

Лифтний тохирлын үнэлгээний үр дүнг актаар баримтжуулах ба паспортад хаяглалт, тэмдэглэл хийнэ.

5. Ашиглалтын тогтоосон хугацаа нь дууссан лифтний тохирлын үнэлгээг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу итгэмжлэгдсэн (эрх бүхий) байгууллага оношлолын хэлбэрээр гүйцэтгэнэ;

5.1. лифтийг оношлохдоо дараах зүйлийг тодорхойлно:

- ашиглалтын хугацаа дууссан лифт нь энэхүү техникийн зохицуулалтын 1-р хавсралтаар тогтоосон аюулгүй байдлын ерөнхий шаардлага (лифтний зориулалтыг харгалзан) болон бусад тусгай шаардлагуудтай нийцэж байгаа эсэх;

- техникийн зохицуулалтын шаардлагад лифтний тохирлыг нийцүүлэх арга хэмжээ, хэрэгжилтийн хугацаа болон авах шаардлагатай арга хэмжээ (түүний дотор лифтний шинэчлэлт);

## 5.2. Лифтийг оношлохдоо дараах зүйлийг үйлдлийг гүйцэтгэнэ:

- лифтний тоног төхөөрөмж түүний дотор лифтний ослоос хамгаалах хэрэгслийн гэмтэл согог, догол, зэврэлт ба элэгдлийн зэргийг тодорхойлох;
- арлын металл хийц, бүхээгийн зүүлтүүр, эсрэг ачаа, чиглүүлэгч тэдгээрийн бэхэлгээний элементүүдийг хянах;
- цахилгаан тоног төхөөрөмж, сүлжээний тусгаарлалтыг турших, лифтний тоног төхөөрөмжийн газардуулгад (нойлтуулга) нүдэн үзлэг болон хэмжих шалгалтыг хийх.

Оношлолыг гүйцэтгэсэн талаарх мэдээллийг лифтний паспорт дээр бичнэ;

## 5.3. Оношлолын үр дүнг үндэслэн дараах зүйлийг агуулсан дүгнэлтийг гаргана:

- лифтийг ашиглах нөхцөл болон боломжит хугацааг сунгах;
- лифтийг шинэчлэх эсвэл солих зөвлөмж.

Лифтийг шинэчилж эсвэл сольсны дараа, энэхүү бүлгийн 3-р заалтад заасан журмын дагуу тохирлын үнэлгээг хийнэ.

Шинэчилсэн лифтний тохирлыг үнэлэхдээ дараах зүйлийг нэмж гүйцэтгэнэ:

- шинэчилсэн лифтний тохирол нь техникийн зохицуулалтын 1-р хавсралтад заасан аюулгүй байдлын ерөнхий (лифтний зориулалтыг харгалзан) ба тусгай шаардлагаудтай нийцэж байгаа эсэхийг шалгах;
- лифтийг шинэчилж, тоног төхөөрөмжийг суурилуулах зураг төслийн баримт бичгийн тохирлыг шалгах;
- ашиглалтын хугацаа нь дууссан лифтний тохирлын үнэлгээний үр дүнгийн дүгнэлтэд заасан, шинэчлэх зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах.

Хүсэлт гаргагч нь тохирлын үнэлгээний дүнг үндэслэн, тохирлын мэдүүлгийг бүрдүүлж, лифтийг ашиглах хугацааг шинээр тогтоон, ашиглалтын хугацаа, техникийн бэлэн байдлын тухай паспортад хаяглалт, тэмдэглэгээ хийж, лифтийг ашиглалтад оруулна;

5.4. шинэчилж, солих шаардлагагүй лифтний ашиглалтын хугацааг уртасгах боломжтой тохиолдолд, түүнийг зориулалтын дагуу ашиглахаар хугацааг нь шинээр тогтооно;

5.5. Энэхүү техникийн зохицуулалт хүчин төгөлдөр болохоос өмнө ашиглалтад орсон, мөн ашиглалтын хугацаа дууссан лифтнүүдийг тус зохицуулалт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 жилийн дотор, техникийн зохицуулалтын шаардлагад бүрэн нийцүүлэх ёстой.

(Энэхүү заалтыг Евроазийн эдийн засгийн комиссын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн N 112 тоот шийдвэрээр олон улсын хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн даган мөрддөг.)

### **Бүлэг 7. Зах зээлд гаргах, оруулах бүтээгдэхүүний хаяглалт, тэмдэглэгээ**

1. Лифтийг үйлдвэрлэж худалдаанд Зах зээлд дээр гаргах, импортоор нийлүүлэх оруулах лифт, ослоос хамгаалах хэрэгслүүд нь аюулгүй байдлын шаардлагыг хангаж, тохирлын үнэлгээнд тэнцсэн тохиолдолд бүтээгдэхүүний нэгдсэн хаяглалт, тэмдэглэгээтэй байна.

2. Зах зээлд Худалдаанд гаргах, импортоор оруулах бүтээгдэхүүн - лифт, ослоос хамгаалах хэрэгслүүдийг зах зээлд гаргахаас өмнө нэгдсэн хаяглалт, тэмдэглэгээг хийнэ.

3. Зах зээлд дээр гаргах, оруулах бүтээгдэхүүний нэгдсэн хаяглалт, тэмдэглэгээг батлагдсан жагсаалтын дагуу лифт, түүний ослоос хамгаалах хэрэгсэл тус бүр дээр байрлуулж, түүний ашиглалтын баримт бичигт тусгана.

4. Зах зээлд дээр гаргах, оруулах бүтээгдэхүүний нэгдсэн хаяглалт, тэмдэглэгээ бүхий лифт, ослоос хамгаалах хэрэгсэл нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг харуулна.

5. Зах зээлд дээр гаргах, оруулах бүтээгдэхүүний нэгдсэн хаяглалт, тэмдэглэгээг лифтний ашиглалтын нийт хугацаанд ойлгомжтой, тодорхой дүрслэл бүхий ямар ч хэлбэрээр байрлуулж болно.

### **Бүлэг 8. Хамгаалах тохиролцоо тогтолцоо**

1. Иргэдийн амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд аюул учруулж болзошгүй лифт түүний ослоос хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэх, импортоор оруулах, ашиглахыг хязгаарлах, хориглох бүхий л арга хэмжээг авч шийдвэр гаргах үүрэгтэй. Эрх бүхий байгууллага нь дээрх шийдвэрийг гаргасан шалтгаан, авсан арга хэмжээ \*8.1) шаардлагыг тайлбарласан нотлох баримтыг гаргаж, түүний талаар мэдэгдэх үүрэгтэй.

2. Дараах тохиолдол нь хамгаалалтын арга хэмжээ авах үндэслэл болно:

- техникийн зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөхгүй байх;
- энэхүү техникийн зохицуулалттай холбоотой стандартуудыг мөрдөхдөө тухайн аль нэг стандартыг буруу хэрэглэсэн;
- лифтийг зах зээлд гаргахыг хориглосон бусад шалтгаанууд.

## **Бүлэг 9. Шилжилтийн үе**

Энэхүү техникийн зохицуулалт хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө Монгол улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас олгосон лифт, түүний ослоос хамгаалах хэрэгслийн тохирлын гэрчилгээ нь тус гэрчилгээнд заасан хугацаа дуусах хүртэл хүчин төгөлдөр байна.

### **Аюулгүй байдлын шаардлага**

1. Лифтний аюулгүй байдлыг хангахын тулд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

1.1. лифтний дараах тоног төхөөрөмжид үйлчлүүлэгч болон гаднын хүмүүс хүрэх боломжгүй байна:

- тоног төхөөрөмжийг байрлуулсан удирдлагын шкаф;
- машины өрөө;
- блокийн өрөө;
- лифтний хонгилд байрлах төхөөрөмжүүд (бүхээгт байрлуулсныг эс тооцно);

1.2. лифтний тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгүүдтэй харьцсаны улмаас үйлчлүүлэгч болон гаднын хүмүүсийг гэмтэхээс хамгаалах арга хэмжээ авсан эсэх;

1.3. хонгилын хаалгыг хаагаагүй, түгжээгүй, тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх хаалга, ослын хаалга, үзлэгийн нээлхийний таг, бүхээгийн хаалга хаагдаагүй тохиолдолд бүхээгийн хөдөлгөөнийг зогсоох, хамгаалалтын хэрэгсэл, хоригийн тоноглолтой байна. Энэхүү шаардлага нь бүхээг нь давхрын түвшинд ойртох үед автомат хаалгыг урьдчилан нээх болон зорчигчдыг суух/буух үед бүхээгийг давхрын түвшинд хүргэх (тэгшлэх) лифтний хийцэд тусгайлан заасан зогсоолын горимд хамаарахгүй;

1.4. мэргэжлийн ажилтан гацаж, зогссон бүхээгээс хүмүүсийг аюулгүй нүүлгэн шилжүүлэх боломжтой байна;

1.5. үйлчлүүлэгч болон гаднын хүмүүс хүрэлцэж болох лифтний төхөөрөмж нь тэдэнд аюул учруулахаар тэгш бус гадаргуутай байж болохгүй;

1.6. зорчигч тээвэрлэх болон цахилгаан тасрах үед бүхээгийг гэрэлтүүлэх хэрэгсэлтэй байна;

1.7. лифтний тоног төхөөрөмж нь лифт ажиллах цаг агаарын болон газар хөдлөлтийн нөхцөлд нийцсэн байх ёстой;

1.8. бүхээг эсвэл барилга байгууламжийн давхрын зогсоолоос хонгил руу унахаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл ба (эсвэл) арга хэмжээний бэлэн байдлыг хангасан байна;

1.9. лифтний хаалганы нүхний хэмжээ нь бүхээг рүү орох, гарах болон түүнд ачаа ачих, буулгах үеийн аюулгүй байдлыг хангасан байна;

1.10. давхрын зогсоолын шал ба бүхээгийн босго хоорондын хэвтээ болон босоо чиглэлийн зай хэмжээ нь бүхээгт орох, гарах аюулгүй байдлыг хангасан байна;

1.11. бүхээг ба хонгилын бүтээцийн элементүүдийн хоорондох зай нь хонгил, бүхээгийн хаалга онгорхой байх үед, түүнчлэн бүхээг нь давхрын зогсоолд байрлах үед хүн хонгил руу нэвтрэх боломжгүй байна;

1.12. автоматаар хаагддаг бүхээг болон хонгилын хаалга нь түүний хавтасны хооронд байрлах хүн, ачааг шахах хүчнээс шалтгаалах гэмтлийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, багасгах тоноглолтой байна;

1.13. бүхээг, татах элементүүд, бүхээгийн зүүлтүүр, тулгуур, эсрэг ачаа, тэдгээрийн бэхэлгээний элементүүд нь лифтийг зориулалтын дагуу ашиглах, турших явцад үүсэх ачааллыг тэсвэрлэхээр бүтээгдсэн байна;

1.14. зорчигч тээвэрлэх зориулалттай бүхээг нь хоёр талын хооронд холбоо барих хэрэгслээр тоноглогдсон байх ба ингэснээр зорчигч гаднаас тусламж дуудах боломжтой байна;

1.15. хэвийн ажиллагааны горимд бүхээгийг хэт ачаалалд оруулахаас урьдчилан сэргийлэх хэрэгсэлтэй байна;

1.16. бүхээгийн хөдөлгөөнийг ажлын хязгаарын байрлалаас хэтэрч гарахаас хязгаарлах хэрэгсэлтэй байна;

1.17. зорчигч гэмтэх, тоног төхөөрөмжийн эвдрэх эрсдэлийг бууруулах зориулалттай, бүхээгийг доош унах үед ажиллах хэвийн хурд хэтрэхээс хязгаарлах хэрэгсэлтэй байна;

1.18. баригч болон зөөлөвч тулгуурын ажиллагаа нь бүхээгийн хөдөлгөөнийг удаашруулснаар зорчигчийн бэртэл гэмтэл, тоног төхөөрөмжийн эвдрэх эрсдэлийг бууруулах асуудлыг шийдвэрлэсэн байна;

1.19. зорчигч тээвэрлэх зориулалттай бүхээгт агаарын солилцоог хангасан байна;

1.20. тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх ажлын бүс, орчны хэмжээ, байршил нь тус ажлыг аюулгүй гүйцэтгэх боломжийг хангасан байна;

1.21. лифтний төхөөрөмжид ажилтан аюулгүй хүрч, үйлчлэх боломжтой байна;

1.22. хонгил дахь ажлын тавцан болон бүхээгийн дээвэр рүү ажилтнууд аюулгүй орох, түүнээс гарах гарцтай байна;

1.23. ажлын тавцан ба (эсвэл) бүхээгийн дээвэр нь (ажилтнууд байрласан тохиолдолд) түүний дээр үйлчлэх ачааллыг тэсвэрлэх ёстой;

1.24. бүхээг болон (эсвэл) бүхээгийн дээвэр дээр байрлах ажлын тавцангаас ажилтнууд унах эрсдэлийг бууруулах хэрэгсэл, арга хэмжээг авсан байна;

1.25. засвар, техникийн үйлчилгээний явцад ажилтнууд бүхээгийн хөдөлгөөнийг зогсоох, удирдах хэрэгсэлтэй байна. Хонгилын дагуу ажилтнуудыг шилжүүлэх шаардлагатай бол бүхээгийн дээрээс ажилтнууд хөдөлгөөнийг аюулгүй хурдаар удирдах, зогсоох хэрэгслээр тоноглогдсон байна. Эдгээр хэрэгсэлд зорчигч болон гаднын хүмүүс нэвтрэх боломжгүй байна;

1.26. лифт болон түүний эд ангиудын удирдлагагүй хөдөлгөөнөөс шалтгаалж лифтний хонгил дахь ажилтнуудыг гэмтээхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, (эсвэл) хэрэгсэлтэй байна;

1.27. шкив, ремень, блок, хөдөлгүүрийн цухуйсан гол, хөтлөх болон одон араа, хөтлөгч гинж зэрэг лифтний тоног төхөөрөмжийн элементүүдийн эргэх хөдөлгөөнд өртөж, гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ ба (эсвэл) хэрэгсэлтэй байна;

1.28. ажилтнууд ажил аюулгүй гүйцэтгэхэд хангалттай, орон зайг гэрэлтүүлэх хэрэгсэлтэй байна;

1.29. лифтний удирдлагын хэрэгсэлтэй харьцах, түүний гүйдэл дамжуулах хийцэд хүрэх үед зорчигч, гаднын хүмүүс болон үйлчилгээний ажилтнуудын цахилгааны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, (эсвэл) хэрэгсэлтэй байна;

1.30. хонгилын хаалганы гал тэсвэрлэх хязгаарыг галын аюулгүй байдлын шаардлагын дагуу тогтоосон байна;

1.31. барилга байгууламжид гал түймрийн аюул гарсан тохиолдолд зорчигчид бүхээгээс аюулгүй гарах боломжоор хангагдах арга хэмжээг авсан байна;

1.32. Лифтийг аюулгүй буулгаж, тээвэрлэх асуудлыг урьдчилан төлөвлөж, хангасан байна.

2. Хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүсийг тээвэрлэх зориулалттай лифтний аюулгүй байдлыг хангахын тулд дараах тусгай шаардлагыг хангасан байна:

2.1. бүхээгийн хаалга, хонгилын зай хэмжээснүүд нь бүхээгт орох, гарах аюулгүй байдлыг хангах, түүнчлэн бүхээгт тэргэнцэртэй зорчигчийг байрлуулах боломжтой байна;

2.2. тэргэнцэртэй зорчигчийг дагалдах хүнгүйгээр тээвэрлэх зориулалттай лифтний бүхээг ба хонгилын хаалга автоматаар нээгдэж, хаагддаг байх ёстой;

2.3. лифтний бүхээг нь дор хаяж нэг бариулаар тоноглогдсон байх ёстой бөгөөд байршил нь хэрэглэгчийг бүхээгт нэвтрэх, удирдлагын тоноглолд хүрэх үйлдлийг хөнгөвчлөх ёстой;

2.4. бүхээг болон давхрын зогсоолын шалны босго хоорондын хэвтээ ба босоо зай нь тэргэнцэртэй зорчигч бүхээгт аюулгүй нэвтрэх, гарах боломжийг хангах ёстой;

2.5. лифтний бүхээг болон давхрын зогсоолд байрлах удирдлага, дохиоллын тоноглолууд (дуут болон гэрэл) нь хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд ажиллуулах үед аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх ёстой.

3. Гал түймрийн үед гал сөнөөгчдийг тээвэрлэх зориулалттай лифтний аюулгүй байдлыг хангахын тулд дараах тусгай шаардлагыг хангасан байна:

3.1. бүхээгийн хэмжээ, лифтний даац нь гал унтраах хэрэгсэл бүхий гал сөнөөгчид болон гал түймрийн үед аврагдсан хүмүүсийг тээвэрлэх шаардлагыг хангасан байна.

3.2. лифтний удирдлагын ба дохиолол систем нь гал сөнөөгчдийн шууд удирдлага дор ажиллах ёстой. Лифтийг удирдах бусад горимыг идэвхгүй болгосон байна;

3.3. бүлгийн удирдлагын системтэй хослуулсан бусад лифтнүүдийн ажиллагаанаас үл хамааран лифтийг удирдах горимтой байна;

3.4. лифтний бүхээг болон үндсэн зогсоолын (товлосон) давхарт бүхээгийн тухайн үеийн байршил, хөдөлгөөний чиглэлийг нүдэнд харагдахаар мэдээлэлтэй байна;

3.5. лифтний хонгилын хаалга нь галд тэсвэртэй байх ёстой бөгөөд галд тэсвэртэй байх хязгаарыг барилга байгууламжийн галын аюулгүй байдлын шаардлагын дагуу гүйцэтгэсэн байна;

3.6. давхрын хооронд зогссон бүхээгээс гал сөнөөгчдийг аврах арга хэмжээ ба (эсвэл) хэрэгсэлтэй байна;

3.7. бүхээгийн хийцэд шатах, утаа үүсгэх чадвар, дөл тархах, шатах үед хорт утаа гаргах зэрэг үзүүлэлтүүдийг тооцсон галын аюулын эрсдэлийг бууруулах материалыг ашиглана.

4. Лифтний аюулгүй байдлыг хангахын тулд диспетчерийн хяналтын тоноглолтой холбохдоо дараах мэдээллийг дамжуулах боломжийг урьдчилан төлөвлөсөн байна:

цахилгааны аюулгүй байдлын хэлхээг идэвхжүүлсэн тухай;

хонгилын хаалгыг зөвшөөрөлгүй онгойлгосон тухай;

машины өрөөгүй лифтний удирдлагын тоноглолын хаалгыг (тагийг) онгойлгосон тухай.

5. Лифтний тоног төхөөрөмжийг зориуд гэмтээх боломжтой барилга, байгууламжид суурилуулах лифтний аюулгүй байдлыг хангахын тулд дараах тусгай шаардлагыг хангасан байна:

5.1. бүхээгийн дотоод хийц, түүнчлэн ханын засал, өнгөлгөө, тааз, шалыг зориуд гэмтээх, галд өртөх эрсдэлийг бууруулах зориулалтын материалаар хийгдсэн байх ёстой;

5.2. бүхээгт болон давхрын зогсоол дахь удирдлага, дохиолол, гэрэлтүүлгийн тоноглолууд нь зориуд гэмтээх, галд өртөх эрсдэлийг бууруулах материалаар хийгдсэн байх ёстой;

5.3. хонгилыг битүү, үргэлжилсэн хашлагаар тусгаарлах шаардлагатай;

5.4. давхрын зогсоолд бүхээг байхгүй үед хонгилын хаалгыг зөвшөөрөлгүй онгойлгосон тохиолдолд лифтийг "хэвийн ажиллагаа" горимоос гаргах хэрэгсэл байгаа эсэх. "Хэвийн ажиллагаа" горим руу буцаах ажиллагааг үйлчилгээний ажилтнууд гүйцэтгэх ёстой.

**Гэрчилгээжилтэнд заавал хамрагдах лифтний ослоос хамгаалах хэрэгслийн  
жагсаалт**

1. Зөөлөвч тулгуур:

- энерги хуримтлуулдаг төрөл (шугаман үзүүлэлттэй, энерги хуримтлуулах  
төрлөөс бусад):

- шугаман бус үзүүлэлттэй;

- буцах хөдөлгөөнийг нь зөөлрүүлсэн;

- энерги саринуулдаг (буцаах пүрштэй шингэний ажиллагаатай) төрөл

2. Ослоос хамгаалах шингэний аппарат (хамгаалах хавхалга).

3. Хонгилын хаалганы цоож.

4. Баригч.

5. Хурд хязгаарлагч.

**"Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын шаардлагад лифт,  
лифтний ослоос хамгаалах хэрэгслийн тохирлыг баталгаажуулах схемийн  
агуулга ба хэрэглээ.**

1. Схем 1с:

1.1. магадлан итгэмжлэгдсэн туршилтын лаборатори:

“техникийн зохицуулалт”-ын жагсаалтад орсон стандартын дагуу лифтийг суурилуулах объект эсвэл туршилтын самбар дээр туршилт ба үзүүлэлтүүдэд хэмжилт хийх;

туршилт, хэмжилтийн үр дүнг тэмдэглэлд тусгана.

1.2. баталгаажуулалтын байгууллага:

гэрчилгээжүүлэх объектод туршилт, хэмжилт хийсэн үр дүн, техникийн зохицуулалтын шаардлагын тохиролд дүн шинжилгээ хийх;

үйлдвэрлэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийх;

техникийн зохицуулалтын 6 дугаар зүйлд заасан мэдээлэл, нотлох материал, шинжилгээ, түүнчлэн итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн хийсэн туршилт, хэмжилтийн үр дүнг үндэслэн гаргасан тохирлын гэрчилгээг хүсэлт гаргагчид олгоно;

Гэрчилгээжүүлсэн объектод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ. Гэрчилгээжүүлсэн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт хийх хугацааг баталгаажуулалтын байгууллага тогтоох боловч жилд нэгээс доошгүй удаа байх нь зүйтэй.

2. Схем 3с (нэгж хугацаанд үйлдвэрлэгдсэн багц) ба схем 4с (зөвхөн нэг удаа үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний хувьд):

2.1. магадлан итгэмжлэгдсэн туршилтын лаборатори:

Техникийн зохицуулалттай холбоотой стандартаар тогтоосон дараалал, цар хүрээний дагуу лифтийг суурилуулсан байршил эсвэл туршилтын самбар дээр түүний туршилт болон үзүүлэлтийн хэмжилтүүдийг хийнэ;

туршилт, хэмжилтийн үр дүнг тэмдэглэлд тусгана;

## 2.2. Баталгаажуулалтын байгууллага:

гэрчилгээжүүлэх объект, туршилтын үр дүн, хэмжилт нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ;

техникийн зохицуулалтын 6 дугаар зүйлд заасан мэдээлэл, нотлох материал, шинжилгээ, түүнчлэн итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн хийсэн туршилт, хэмжилтийн үр дүнг үндэслэн гаргасан тохирлын гэрчилгээг хүсэлт гаргагчид олгоно;

## 3. Схем 4д (мэдүүлэх схем):

### 3.1. Хүсэлт гаргагч:

техникийн зохицуулалтын 6 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг бэлтгэнэ; бүрдүүлнэ

лифтний тохирлын үнэлгээ буюу техникийн магадлал хийлгэхээр итгэмжлэгдсэн туршилтын лабораторид (төв) өргөдөл гаргана;

### 3.2. магадлан итгэмжлэгдсэн туршилтын лаборатори (төв):

лифтний тохирлын үнэлгээ буюу техникийн магадлалыг хийнэ;

лифтний техникийн магадлалын актыг бүрдүүлнэ;

3.3. хүсэлт гаргагч нь нотлох баримт, техникийн магадлалын үр дүнг үндэслэн тохирлын мэдүүлэг гаргана.